



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/259

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.6 дахь заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээнд тусгагдсаны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны нээлтийг "Хан Алтай ресурс" ХХК-ийн уурхайд зохион байгуулсан арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах 596,500 (таван зуун ерэн зургаан мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2018 оны 4 дугаар сарын 26-ны өдрийн 253 дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Үнэ	Нийт дүн
1	Шатахуун	литр	90	3850	346,500
2	Жолоочийн хөлс			250,000	250,000
	Дүн				596,500

__оОо__